

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/076/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Баянхонгор хот  
2026.02.15

**2026**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn  
Ахлах аудитор: Б.Азбаяр  
Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
<b>4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>12</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>14</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/66  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хөрөнгө шилжүүлэх тогтоол, түүний биелэлтэд дотоод хяналт хэрэгжүүлэхгүй байгаа нь тухайн асуудалтай холбоотой зөрчил арилахгүй, давтагдан гарах эрсдэлтэй байна.

6426050204  
/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгадагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>28,221,993.23</u></b>	<b><u>20,378,016.05</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	2,833,814.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,833,814.89
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,221,993.23	17,544,201.16
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	28,221,993.23	17,544,201.16
35410	Бичиг хэргийн материал	5,732,160.00	1,748,500.00
35420	Аж ахуйн материал	2,115,290.00	2,215,290.00
35440	Түлш, шатах тослох материал	529,313.23	195,731.16
35450	Барилгын засварын материал	00.00	2,900.00
35470	Бусад хангамжийн материал	19,845,230.00	13,381,780.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>404,086,360.80</u></b>	<b><u>284,096,091.07</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	404,086,360.80	284,096,091.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	404,018,860.80	245,258,591.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	152,287,400.00	2,268,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,486,483.51)	(1,627,131.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	348,690,000.00	318,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(157,176,833.71)	(187,951,500.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,087,642.00	160,300,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,371,127.37)	(98,142,559.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,525,950.00	89,175,540.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,537,686.61)	(37,754,126.82)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	67,500.00	38,837,500.00
39301	Програм хангамж	1,170,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,102,500.00)	(1,187,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	38,525,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>432,308,354.03</u></b>	<b><u>304,474,107.12</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4,082,944.88</u></b>	<b><u>25,290,927.01</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,082,944.88	25,290,927.01
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,082,944.88	25,290,927.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,082,944.88	700,326.01
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	24,590,601.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	14,090,601.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	10,500,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>428,225,409.15</u></b>	<b><u>279,183,180.11</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	428,225,409.15	279,183,180.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	206,028,121.00	206,028,121.00
51101	Өмч: - төрийн	206,028,121.00	206,028,121.00

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	222,197,288.15	73,155,059.11
51210	Өмнөх үеийн үр дүн	222,197,288.15	222,197,288.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(149,042,229.04)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>432,308,354.03</u></b>	<b><u>304,474,107.12</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,187,282,055.00</b>	<b>1,711,694,398.37</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>95,453,808.00</b>	<b>45,694,398.37</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	95,453,808.00	45,694,398.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,453,808.00	45,694,398.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	11,550.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	00.00	45,025,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал	00.00	657,848.37
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,091,828,247.00</b>	<b>1,666,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	115,937,247.00	37,157,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,937,247.00	37,157,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,975,891,000.00	1,628,842,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,975,891,000.00	1,628,842,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,138,452,750.16</b>	<b>1,762,869,627.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,138,452,750.16</b>	<b>1,762,869,627.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,979,419,714.12	1,682,488,102.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	891,829,156.00	957,950,745.23
210101	Үндсэн цалин	571,646,687.00	396,435,290.23
210102	Нэмэгдэл	214,506,249.00	249,496,312.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,640,000.00	65,200,000.00
210104	Урамшуулал	69,036,220.00	246,819,143.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	108,349,769.96	117,958,233.01
210201	Тэтгэврийн даатгал	75,635,138.37	82,520,325.89
210202	Тэтгэмжийн даатгал	8,840,352.42	9,477,405.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,459,145.89	4,738,702.88
210204	Ажилгүйдлийн даатгал	3,883,025.94	4,244,359.80
210205	Эрүүл мэндийн даатгал	15,532,107.34	16,977,438.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	1,500,000.00
210304	Байрны түрээс	00.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	128,996,360.00	36,983,079.44
210401	Бичиг хэрэг	20,464,250.00	13,945,550.00

**Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	33,611,356.00	18,875,411.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,446,100.00	3,162,118.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,750.00	1,000,000.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	70,698,904.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	10,800,000.00
210502	Хоол, хүнс	00.00	10,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,504,600.00	28,217,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	192,000.00	00.00
210604	Урсгал засвар	37,312,600.00	28,217,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	26,365,467.00	18,160,250.00
210702	Дотоод албан томилолт	8,451,467.00	11,540,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	17,914,000.00	6,620,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	309,812,527.00	209,597,806.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	305,647,801.00	207,144,472.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,456,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,146.00	480,084.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,507,580.00	1,407,250.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	476,561,834.16	301,320,088.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	338,145,743.88	193,581,819.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,537,000.00	17,700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,879,090.28	90,038,269.63
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	159,033,036.04	80,381,525.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	136,351,047.00	54,383,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,997,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	27,020,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,937,247.00	13,057,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,413,800.00	1,308,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	22,681,989.04	25,998,225.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,681,989.04	25,998,225.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>48,829,304.84</b>	<b>(51,175,228.94)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	7,819,924.85	97,867,000.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,819,924.85	97,867,000.10
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(7,819,924.85)	(97,867,000.10)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>41,009,379.99</b>	<b>(149,042,229.04)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,091,828,247.00</u></b>	<b><u>1,666,011,550.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>11,550.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	11,550.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	11,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	11,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,091,828,247.00</b>	<b>1,666,000,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	115,937,247.00	37,157,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,937,247.00	37,157,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,975,891,000.00	1,628,842,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,975,891,000.00	1,628,842,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,998,421,947.00</u></b>	<b><u>1,643,121,550.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,998,421,947.00</b>	<b>1,643,121,550.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,838,302,910.96</b>	<b>1,565,845,525.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	888,230,884.00	948,924,915.00
210101	Үндсэн цалин	295,072,764.00	338,376,003.00
210102	Нэмэгдэл	234,808,800.00	289,684,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,240,000.00	67,780,000.00
210104	Урамшуулал	316,109,320.00	253,084,912.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	107,170,328.96	120,343,700.00
210201	Тэтгэврийн даатгал	74,428,099.00	82,633,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,179,600.00	9,427,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,113,129.96	4,713,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,089,700.00	4,713,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,359,800.00	18,855,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	1,500,000.00
210304	Байрны түрээс	00.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	46,820,350.00	30,516,611.00
210401	Бичиг хэрэг	6,476,500.00	7,935,390.00
210402	Тээвэр, шатахуун	32,200,000.00	17,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,451,100.00	2,706,221.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,692,750.00	2,375,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	10,800,000.00
210502	Хоол, хүнс	00.00	10,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	108,749,704.00	15,285,900.00

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	83,439,704.00	110,000.00
210602	Тавилга	1,000,000.00	330,000.00
210604	Урсгал засвар	24,310,000.00	14,845,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>26,451,467.00</b>	<b>18,872,250.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,451,467.00	11,540,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	18,000,000.00	7,332,250.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>295,153,527.00</b>	<b>188,972,349.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	290,988,801.00	186,178,618.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,456,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,146.00	480,084.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,507,580.00	1,747,647.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>365,726,650.00</b>	<b>230,629,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	348,544,200.00	210,650,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,182,450.00	19,979,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>160,119,036.04</b>	<b>77,276,025.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>137,437,047.00</b>	<b>51,277,800.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	11,200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	27,020,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,937,247.00	13,057,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	101,499,800.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,681,989.04</b>	<b>25,998,225.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,681,989.04	25,998,225.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>93,406,300.00</u></b>	<b><u>22,890,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>93,406,300.00</b>	<b>22,890,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>93,406,300.00</b>	<b>22,890,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>93,406,300.00</b>	<b>22,890,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	93,406,300.00	22,890,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(93,406,300.00)</u></b>	<b><u>(22,890,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	206,028,121.00	2,403,666.00	(176,488,279.74)	00.00	31,943,507.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>206,028,121.00</b>	<b>2,403,666.00</b>	<b>(176,488,279.74)</b>	<b>00.00</b>	31,943,507.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,353,397.65	00.00	10,353,397.64
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>206,028,121.00</b>	<b>00.00</b>	<b>222,197,288.15</b>	<b>00.00</b>	428,225,409.15
D01	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>206,028,121.00</b>	<b>00.00</b>	<b>222,197,288.15</b>	<b>00.00</b>	428,225,409.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>206,028,121.00</b>	<b>00.00</b>	<b>222,197,288.15</b>	<b>00.00</b>	428,225,409.15
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(149,042,229.04)	00.00	(149,042,229.04)
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>206,028,121.00</b>	<b>00.00</b>	<b>73,155,059.11</b>	<b>00.00</b>	279,183,180.11

**Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,721,677,100.00	1,602,855,825.00	118,821,275.00	93.1
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,721,677,100.00	1,602,855,825.00	118,821,275.00	93.1
Орон нутгийн төсвөөс	1,721,677,100.00	1,602,855,825.00	118,821,275.00	93.1
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,721,677,100.00	1,602,855,825.00	118,821,275.00	93.1
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,721,677,100.00	1,602,855,825.00	118,821,275.00	93.1
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,679,656,800.00	1,564,635,525.00	115,021,275.00	93.2
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	949,062,900.00	948,924,915.00	137,985.00	100.0
Үндсэн цалин	338,513,900.00	338,376,003.00	137,897.00	100.0
Нэмэгдэл	289,684,000.00	289,684,000.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	67,780,000.00	67,780,000.00	-	-
Урамшуулал	253,085,000.00	253,084,912.00	88.00	100.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	120,343,700.00	120,343,700.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	82,633,700.00	82,633,700.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	9,427,600.00	9,427,600.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	4,713,700.00	4,713,700.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	4,713,700.00	4,713,700.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	18,855,000.00	18,855,000.00	-	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,599,900.00	30,516,611.00	6,083,289.00	83.4
Бичиг хэрэг	9,100,000.00	7,935,390.00	1,164,610.00	87.2
Тээвэр, шатахуун	21,499,900.00	17,500,000.00	3,999,900.00	81.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,706,221.00	293,779.00	90.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,375,000.00	625,000.00	79.2
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	28,000,000.00	27,980,900.00	19,100.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
Тавилга	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.0
Урсгал засвар	5,000,000.00	4,980,900.00	19,100.00	99.6
<b>Томилолт, зочны зардал</b>	20,557,600.00	18,872,250.00	1,685,350.00	91.8
Дотоод албан томилолт	12,100,000.00	11,540,000.00	560,000.00	95.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	8,457,600.00	7,332,250.00	1,125,350.00	86.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	261,942,700.00	187,172,349.00	74,770,351.00	71.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	255,442,700.00	184,378,618.00	71,064,082.00	72.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,250,000.00	480,084.00	1,769,916.00	21.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	350,000.00	66,000.00	284,000.00	18.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,400,000.00	1,747,647.00	652,353.00	72.8
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	263,150,000.00	230,824,800.00	32,325,200.00	87.7
Бараа үйлчилгээний бусад зардал	237,000,000.00	210,845,800.00	26,154,200.00	89.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,150,000.00	19,979,000.00	6,171,000.00	76.4
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	42,020,300.00	38,220,300.00	3,800,000.00	91.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	42,020,300.00	38,220,300.00	3,800,000.00	91.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,000,000.00	11,200,000.00	3,800,000.00	74.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,020,300.00	27,020,300.00	0.00	100.0
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	0.00	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	0.00	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>37,157,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>37,157,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	24,100,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,500,000.00
210304	Байрны түрээс	1,500,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	10,800,000.00
210502	Хоол, хүнс	10,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,057,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,057,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,057,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	37,157,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	37,157,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,157,500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,373.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Нийгмийн даатгалын шимтгэл мэдээлэхдээ цалин түүнтэй адилтгах орлогыг 2025 оны 9 дүгээр сард 792.0 мянган төгрөгөөр 1 хүн мэдээлээгүй орхигдуулсан, 2025 оны 12 дугаар сард 3 хүн 3,056.2 мянган төгрөгийг илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1-д заасан "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрүүтэй мэдээлсэн цалин түүнтэй адилтгах орлогын 3,848.2 мянган төгрөгийг үнэн зөв мэдээлж, зөрчлийг арилган, нийгмийн даатгалын байгууллагаас суутган тооцож биелэлтийг эхний хагас жилд багтаан ирүүлэх.

5.1.2. Баянхонгор сумын Номундалай сургуулийн дансанд бүртгэлтэй 38,525.0 мянган төгрөгийн дотуур байрны барилгын газрыг балансаас баланст шилжүүлэн авсан боловч газар эзэмшин эрхийн гэрчилгээ болон газрын цахим системийн мэдээлэл өнөөг хүртэл Баянхонгор сумын Номундалай сургуулийн нэр дээр бүртгэлтэй байна.

Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан “Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд заасан эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх тухай мэдүүлгийг тухайн үл хөдлөх эд хөрөнгө оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу улсын бүртгэлийн байгууллагад гаргана.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай тооцоо нийлж эд хөрөнгийн бүртгэл болон нягтлан бодох бүртгэлийн зөрүүг гарган зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.1.3. Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст төсөв гүйцэтгэлтэй холбоотой 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх албан шаардлага өгөв.

Дээрх шийдвэрүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэл мэдээлэхдээ цалин түүнтэй адилтгах орлогыг 2025 оны 9 дүгээр сард 792.0 мянган төгрөгөөр 1 хүн мэдээлээгүй орхигдуулсан, 2026 оны 12 дугаар сард 3 хүн 3,056.2 мянган төгрөгийг илүү мэдээлсэн байна.	1	3,848.2			1	3,848.2		
Баянхонгор сумын Номундалай сургуулийн дансанд бүртгэлтэй 38,525.0 мянган төгрөгийн дотуур байрны барилгын газрыг балансаас баланст шилжүүлэн авсан боловч газар эзэмшин эрхийн гэрчилгээ болон газрын цахим системийн мэдээлэл өнөөг хүртэл Баянхонгор сумын Номундалай сургуулийн нэр дээр бүртгэлтэй байна.	1	38,525.0			1	38,525.0		
Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст төсөв гүйцэтгэлтэй холбоотой 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0			1	0		
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>42,373.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>42,373.0</b>	<b>0</b>	<b>0</b>

-----oOo-----